



"ХҮН БҮХЭНД ЭЭЛТЭЙ СУРГУУЛЬ" БОЛОХЫН ТӨЛӨӨ...

"Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн хүрээнд Нийслэлийн БГД-ийн 28 дугаар дунд сургуулийн жишээн дээр

Хөгжлийн бэрхшээлтэй хүн ч ердийн эрүүл хүн ч бүгд хүний эрхээ хамгаалуулж, боловсрол, ажил мэргэжил, бусад нийгмийн амьдралд эрх тэгш оролцох боломжоор хангагдах шаардлагатай. Бүх хүн нийгэмд эрх тэгш амьдардаг болохын тулд тус бүрийн хүндрэлд нийцсэн орчин "Зориулалтын орчин"-г бий болгох юм. Энэ утгаараа Монголд ЕБС дээр бага багаар тэрхүү орчинг бүрдүүлэх үйл ажиллагаа хийгдэж эхэлж байна.

Нийслэлийн ерөнхий боловсролын 28 дугаар дунд сургууль нь 9 болон 12 дугаар ангийг төгсөгчдөөс жил бүр хандив цуглуулж, түүнийг юунд зарцуулах тухай багш хамт олноороо ярилцаж шийддэг. 2015 онд мод тарьсан бол 2016

онд "Хүн бүхэнд ээлтэй сургууль" гэсэн уриан дор сургуулийн дотоод орчинг сайжруулах ажлыг хийхээр болсон.

Сургуулийн дотоод орчинг сайжруулах гэдэг нь яг юу вэ гэдгийг дэлгэрэнгүй тайлбарлавал:

1. Сургуулийн орж гарах хаалганы гадна талд налуу зам тавих
2. Ариун цэврийн өрөө (00-ийн өрөө)-нд бариул болон хувцас өлгөх өлгүүр
3. /1-Цайны газар, 2-00-ын өрөө, 3-Номын сан, 4-Мэдээлэл зүйн өрөө, 5-Биеийн тамирын заал, 6-Дуу хөгжмийн өрөө, 7-Эмчийн өрөө/-ний хаалганы хажуу хананд зурагтай хаягийг байршуулсан.



00-ын өрөөний бариул болон өлгүүр

00-ын өрөөний зурагтай хаяг

Цайны газрын зурагт хаяг

Биеийн тамирын өрөөний зурагтай хаяг



Сургуулийн орж гарах хаалганы гадна талын налуу

Эмчийн өрөөний зурагтай хаяг

Сургууль төгсөгчид материалын мөнгийг хандивлаж, багш нар өөрсдөө боловсруулах, байршуулах ажлыг хийсэн. Сургууль доторх өрөөний хаягийг байршуулах тухайд өмнө нь Баянгол дүүргийн нийгмийн халамжийн хэлтсээс "Үгүй хөтөч" нэртэйгээр сургуулийн анги танхим, өрөөнүүдийг хаягжуулах тухай санал тавьж байсан болохоор энэхүү ажлыг хийхээр болсон.

Тус сургуулийн дунд ангийн сургалтын менежер Оюунбилэгээс энэ ажлыг хийхэд анхаарч харгалзаж үзсэн зүйлийн тухай асуухад "Сургуулийн гаднах хаалганы хажуу талын налуу болон 00-ын өрөөний доторх бариулыг байрлуулахдаа гэмтэж бэртсэн болон оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг байлцуулж, тэдний саналыг сонсож байрлуулсан. Мөн өрөөний хаягийг Японы хамтын ажиллагааны байгууллага (JICA)-ын хэрэгжүүлж буй "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн хамт олноос зөвлөгөө авч, холоос харсан ч юуны өрөө болох нь ойлгомжтой байхаар хананд нааж үзсэн" гэж ярьж

байсан. Гаднах хаалганы хажуу талын налуу болон 00-ын өрөөний доторх бариул зэргийг байрлуулах үед технологийн багш нар дизайныг нь гаргаж, өрөөний хаягны дизайныг багш нар бүгд ярилцаж хэн ч харсан ойлгомжтой байдлаар боловсруулсан.

Эдгээрийг байршуулсны дараа эцэг эхчүүдээс "зөвхөн хүүхдэд ч биш өндөр настай хүнд ч ээлтэй сайн ажил болжээ" гэсэн сэтгэгдлүүд ирж байсан. Ялангуяа тус сургуулийн хүүхдүүд 00-ын өрөөнд бариул хийсэн нь "маш сайн болсон" гэж хэлж байсан. Сайн талууд байхын хажуугаар 2 бариулны аль нэгийг нь дахин хэмжиж байрлуулах, 00-ын өрөө болон ангийн гаднах хаягийн хувьд бүх ангид хийж амжаагүй гэх мэт бүрэн дуусгах шаардлагатай ажлууд үлдсэн байдалтай байна. Цаашид ч энэхүү ажлаа үргэлжлүүлэн хийхээр төлөвлөж байна.



Мөн өмнө нь тус сургуульд тэргэнцэртэй хүүхэд суралцаж байсан бөгөөд яг бодит байдал дээр тэргэнцэртэй хүүхдийг сургуульдаа хүлээн авахад 00-ын өрөөний хаалга нарийхан, анги танхим

хооронд шаттай гэх мэт асуудлууд тодорхой харагдаж ирсэн. Цаашид ч тэргэнцэртэй хүүхдийг хэзээ ч хамаагүй хүлээж авахад бэлэн байлгах үүднээс сургуулийн дотоод орчинг сайжруулах ажлуудыг хийх болно. Энэхүү орчинг бүрдүүлэх ажил маань зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд л зориулсан зүйл биш юмаа.

Жишээ нь: 00-ны өрөөнд байгаа угаалтуурын хаалтыг дээр, доор байрлуулсан нь зөвхөн тэргэнцэртэй хүүхдийн төлөө биш, бага ангийн намхан нуруутай хүүхдүүд ч ашиглаж болохуйцаар байршуулсан байгаа."Хүн бүхэнд ээлтэй сургууль" болохын төлөө 28 дугаар сургууль цаашид ч хичээн ажиллах болно.

JICA "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл"

Тус төсөл нь 2015 оны 8 сард БСШУЯ /Одоогийн БСШУСЯ/ болон ХАХНХЯ /Одоогийн ХНХЯ/-ны захиалгаар JICA "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл" START төсөл нэртэйгээр хэрэгжиж эхэлсэн.

Уг төсөл 2019 оны 7 сар хүртэл үргэлжлэх төлөвлөгөөтэй бөгөөд "Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэх, хүүхдийн хөгжлийн дэмжлэг болон боловсролын үйлчилгээний загварыг бий болгох" зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй хамаагүй нэг ч гэсэн хүүхэд чанартай боловсролын үйлчилгээг авч, нийгэмд эрх тэгш амьдрах орчинг бүрдүүлэхийн төлөө Монголын холбогдох салбарын хүмүүстэй хамтран ажиллаж байна.

ТӨСЛИЙН ХОЛБОГДОХ ХАЯГ

БСШУСЯ: Засгийн газрын 3-р байр, 212 тоот
Харилцах утас: 976-9424-0702

ХНХЯ: Сэргээн засал, хөгжлийн үндэсний төв, 228 тоот
Харилцах утас: 976-8634-0702
Мэйл хаяг: jica15start@gmail.com

Төслийн веб хуудас:
<https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/013/index.html>